



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/489

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Мотоблок” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Хөгжил политехник коллежийн барилга /Ховд, Жаргалант сум/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Дөлбадрал	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Гишүүд: Э.Маргад-Эрдэнэ	- Барилгын хөгжлийн төвийн Ховд аймгийг хариуцсан хяналтын инженер
Д.Марал-Эрдэнэ	- Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч
Д.Нямтулга	- Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч
Б.Даваадорж	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Ц.Цогтбаяр	- Жаргалант сумын Засаг дарга
Б.Түмэндэмбэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
З.Өмиртай	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга


- С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн
- Н.Батжаргал - Хөгжил политехник коллежийн аж ахуйн албаны менежер
- Г.Ганжаргал - Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч
- Н.Ням-Эрдэнэ - “Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн ерөнхий инженер
- М.Нансалмаа - “Шим-Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер
- Д.Алтанхуяг - “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер
- Б.Бямбажав - “Бадамлах дөл” ХХК-ийн шугам сүлжээний дарга
- Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Ж.Сүхбаатар - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн
- С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
- С.Бямбасүрэн - Барилгын зураг төслийн “Алтайн газрын хүч” ХХК-ийн захирал
- Т.Бямбажаргал - “Мотоблок” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. “Мотоблок” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

